

2024 оны 02 сарын 19-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.8 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.6 дахь заалт, Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн 2023 оны татварын дараах цэвэр ашгаас 20.6755 хувийг буюу 1,251,991,232.27 /нэг тэрбум хоёр зуун тавин нэгэн сая есөн зуун ерэн нэгэн мянга хоёр зуун гучин хоёр төгрөг хорин долоон мөнгө/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

2. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг 5.60 /таван төгрөг жаран мөнгө/ төгрөгөөр тогтоосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.

4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр олгосугай.

5. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ

